



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 06 сарын 12-ны
өдрийн 6874 дугаарт бүртгэв.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Баянхонгор аймгийн "Чандмань
Баянхонгор" ХК-ийн цэвэр, бохир усны
үйлчилгээний тариф батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн "Чандмань Баянхонгор" ХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хугацааны дараа сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг "Чандмань Баянхонгор" ХК /М.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

3. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг "Чандмань Баянхонгор" ХК /М.Мөнхбат/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2021 оны 48 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтыг энэхүү тогтоолын 2 дахь заалтад заасан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮН

Г.ЦОГТСАЙХАН

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБЯАР

142410170

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 53 дугаар тогтоолын хэвсрэлт

БАЯНХОНГОР АЙМГИЙН "ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР" ХХК-ИЙН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ

Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Айл өрх /тоолууртай/	төг/л	1.5
	Айл өрх /тоолуургүй/	төг/л	2.0
Бохир ус	Айл өрх /тоолууртай/	төг/л	1.5
	Айл өрх /тоолуургүй/	төг/л	2.0

Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	3.0
	Төсөвт байгууллага	төг/л	7.0
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	5.5
	Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	5.0
	Зөөврөөр	төг/л	10.0
Бохир ус	Аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	2.0
	Төсөвт байгууллага	төг/л	5.0
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс, ус, талх нарийн боовны үйлдвэр, мах, сүү боловсруулах үйлдвэр, эмнэлэг	төг/л	4.5
	Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга	төг/л	5.0
	Зөөврөөр	Төг/л	30.0

Гурав. Ус түгээх байр
(НӨАТ-гүй)

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Ус түгээх байр	төг/л	4.00